



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ



**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ,
ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ
ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН**

**Улаанбаатар хот
2020 он**

АГУУЛГА

НЭГ. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	3-4
ХОЁР. ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР	
2.1 Эрүүгийн хэргийн танхим	5-10
2.2 Иргэний хэргийн танхим	11-17
2.3 Захиргааны хэргийн танхим	18-22
ГУРАВ. ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНААС БУСАД АЖЛЫН ТАЛААР	23-25
ДӨРӨВ. ТАМГЫН ГАЗРЫН АЖЛЫН ТАЛААР	26
4.1 Шүүхийн захиргааны удирдлага	27
4.1.1 Шүүгчийн хараат бус байдлыг хангах чиглэлээр	27-28
4.1.2 Шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах чиглэлээр	28-32
4.1.3 Хүний нөөцийн чиглэлээр	32-34
4.1.4 Архивын ажлын чиглэлээр	34-35
4.1.5 Номын сангийн ажлын чиглэлээр	35-36
4.1.6 Цагаатгалын бүртгэлийн чиглэлээр	36
4.2 Шүүхийн зохион байгуулалт	36-39
4.3 Шүүхийн практик судлал	39-43
4.4 Шүүхийн төсөв, санхүү, хангамж, үйлчилгээ	44-48
4.5 Шүүхийн нээлттэй, ил тод байдал	48-50
4.6 Ерөнхий шүүгчийн ажлын алба	50-52
4.12 Шүүхийн гадаад хамтын ажиллагаа	52-57



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ

Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн...


/Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгээс/

НЭГ. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ


Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.

/Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгээс/

**Улсын дээд шүүх 2020 онд нийт 3139 хэрэг хүлээн авч,
танхимуудад хуваарилагдсан байдал:**




**Шүүх хуралдаанаар 1968 хэрэг хянан шийдвэрлэж, тэдгээр нь
танхимуудад ногдсон байдал:**




Улсын дээд шүүхийн эрүү, иргэн, захиргааны хэргийн танхимуудын
2020 онд хүлээж авсан хэргийг өмнөх онтой харьцуулбал:



2020 онд шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн
хэргийг өмнөх онтой харьцуулбал:



Улсын дээд шүүхийн нэг шүүгчид ногдох хэрэг,
ажлын ачааллыг өмнөх онтой харьцуулбал:



ХОЁР. ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР



2.1. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАНХИМ




ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАНХИМ

Эрүүгийн хэргийн танхим 2019 оны үлдэгдэл 38 хэрэг дээр 2020 онд хяналтын шатны журмаар эрүүгийн 1164, цагаатгалын 15, нийт 1217 хэрэг хүлээн авч, эрүүгийн 671, цагаатгалын 14 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, 313 хэргийг шүүгчийн захирамжаар буцааж, хяналтын шатны шүүхийн шийдвэрт гомдол гаргасан 149 хэргийг Ерөнхий шүүгчийн ажлын албанд шилжүүлж, 70 хэргийн үлдэгдэлтэй байна.

Ерөнхий шүүгчид гомдол гаргасан 149 хэргийг шилжүүлж, 135 хэрэгт хариу өгч, 14 хэргийн үлдэгдэлтэй байна.

Нийт хүлээн авсан эрүүгийн 1217 хэргээс:



Эрүүгийн хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдаан нийт 57 өдөр хуралдаж, өдөрт дунджаар 12 хэрэг хэлэлцжээ.

Эрүүгийн хэргийн танхимд хяналтын шатны журмаар ирүүлсэн нийт 1217 хэргээс нэг шүүгчид 178 хэрэг ногдож байна.

Хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзсан нийт 61 захирамжид гомдол гаргаснаас 52 хэргийг шийдвэрлэж, 9 хэргийн үлдэгдэлтэй байна.


Хяналтын журмаар шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэгдсэн 685 хэргийн 48.5 хувь буюу 332 хэргийн тогтоол, магадлалыг хэвээр үлдээж, гомдол, эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож, 22.2 хувь буюу 152 хэргийн тогтоол, магадлалд өөрчлөлт оруулж, 29.3 хувь буюу 201 хэргийн тогтоол, магадлалыг хүчингүй болгожээ.

Тогтоол, магадлалд өөрчлөлт оруулсан 152 хэргийн 11.2 хувь буюу 17 хэргийг Эрүүгийн хууль буруу тайлбарлан хэрэглэсэн, 7.2 хувь буюу 11 хэргийг хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, 9.2 хувь буюу 14 хэргийг хэрэглэх ёстой хууль хэрэглээгүй, 40.1 хувь буюу 61 хэргийн зүйлчлэл өөрчлөлгүйгээр ялыг хөнгөрүүлсэн, 32.3 хувь буюу 49 хэргийг бусад гэсэн үндэслэлээр тус тус өөрчлөлт оруулжээ.

Тогтоол, магадлалыг хүчингүй болгосон 201 хэргийн 26.4 хувь буюу 53 хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт, 17.9 хувь буюу 36 хэргийг шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцааж, 14.4 хувь буюу 29 хэргийг хэрэгсэхгүй болгож (үүнээс 5.6 хувь буюу 12 нь цагаатгалын хэрэг), 41.3 хувь буюу 83 хэргийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, магадлалыг хүчингүй болгожээ.

Хяналтын журмаар Танхимын тэргүүн Б.Цогт 75, шүүгч Ч.Хосбаяр 217, Д.Эрдэнэбалсүрэн 209, Б.Батцэрэн 208, Б.Амарбаясгалан 201, С.Батдэлгэр 85, Д.Ганзориг 73, Ерөнхий шүүгчийн ажлын алба 149 эрүүгийн хэрэг тус тус хүлээн авчээ.

Шүүгч тус бүрийн болон Ерөнхий шүүгчийн ажлын
албаны хүлээн авсан хэрэг




Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн Б.Цогт 684, шүүгч Б.Амарбаясгалан 621, Д.Эрдэнэбалсүрэн 591, Ч.Хосбаяр 589, Б.Батцэрэн 563, Д.Ганзориг 218, С.Батдэлгэр 159 удаа тус тус оролцсоноос;

Танхимын тэргүүн Б.Цогт 632, шүүгч Б.Батцэрэн 16, Д.Эрдэнэбалсүрэн 13, Ч.Хосбаяр 10, Б.Амарбаясгалан 11, шүүгч Д.Ганзориг 3 хэргийн шүүх хуралдааныг даргалж;

Танхимын тэргүүн Б.Цогт 53, шүүгч Ч.Хосбаяр 144, Д.Эрдэнэбалсүрэн 135, Б.Батцэрэн 130, Б.Амарбаясгалан 129, Д.Ганзориг 49, С.Батдэлгэр 45 хэрэг илтгэсэн байна.

Эрүүгийн хэргийн танхимын шүүгчдийн 2020 оны бүтэн жилийн ажлын ачаалал:



Улсын дээд шүүхэд 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хооронд Улсын Ерөнхий Прокурорын газраас улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгуулахаар прокурорын дүгнэлтийг 15 удаа бичиж ирүүлсэн ба нийт 17 хэлмэгдэгчдийг цагаатгасан байна. Хэлмэгдэгчдийн төрөл садангаас цагаатгуулах хүсэлт 9, нөхөн олговор олгох хүсэлт 18 тус тус ирснийг харьяаллын дагуу зохих байгууллагуудад шилжүүлсэн. Энэ хугацаанд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийн цагаатгалын үнэмлэх олгох талаар хэлмэгдэгчдийн төрөл садан болон Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссуудаар дамжуулан 156 өргөдөл, хүсэлтийг хүлээн авч үүнээс цагаатгалын үнэмлэхийг нийтдээ 53 үнэмлэх олгосноос шинээр 21 үнэмлэх, 32 үнэмлэх нөхөн олгожээ.

Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн цагаатгалын 18 хүнд холбогдох 12 хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэсэн үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож, тэднийг цагаатгаж, 5 хүнд холбогдох 2 хэргийн тогтоолд өөрчлөлт оруулж, 1 хэргийн үлдэгдэлтэй байна.

Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн 82.8 хувь буюу 567 хэргийг ялтан, хохирогч, тэдний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн гомдлоор, 1.2 хувь буюу 8 хэргийг иргэний нэхэмжлэгч, хариуцагчийн

гомдлоор, 13.4 хувь буюу 92 хэргийг улсын яллагчийн эсэргүүцлээр, 2.6 хувь буюу 18 хэргийг прокурорын дүгнэлтээр хэлэлцжээ.

Тайлангийн хугацаанд Танхимын тэргүүн Б.Цогт 16, шүүгч Б.Батцэрэн 65, шүүгч Ч.Хосбаяр 61, шүүгч Д.Эрдэнэбалсүрэн 55, шүүгч Б.Амарбаясгалан 53, шүүгч С.Батдэлгэр 29, шүүгч Д.Ганзориг 23 нийт 302 хэргийг хянаж шүүгчийн захирамжаар буцаасан байна.

Эрүүгийн хэргийн танхим 2020 онд нийт 271 албан бичиг, 53 өргөдөл, гомдол хүлээн авснаас Танхимын тэргүүн Б.Цогт 210 албан бичиг, 36 өргөдөл гомдол, шүүгч С.Батдэлгэр 33 албан бичиг, 6 өргөдөл гомдол, шүүгч Ч.Хосбаяр 5 албан бичиг, 3 өргөдөл гомдол, шүүгч Д.Эрдэнэбалсүрэн 5 албан бичиг, 1 өргөдөл гомдол, шүүгч Б.Амарбаясгалан 4 албан бичиг, 1 өргөдөл гомдол, шүүгч Б.Батцэрэн 1 өргөдөл гомдол тус тус хянан шийдвэрлэж, одоо Танхимын тэргүүн Б.Цогт 13 албан бичиг, 5 өргөдөл гомдол, шүүгч Б.Батцэрэн 1 албан бичгийн үлдэгдэлтэй байна.

Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний захирамж 1098 гарснаас шүүхийн харьяалал тогтоох тухай 54, хэрэг хянан шийдвэрлэх хугацаа сунгах тухай 133, шүүгч томилон ажиллуулах тухай 109, хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхгүй тухай 9, шүүх хуралдаан даргалагч, шүүх бүрэлдэхүүн томилсон шийдвэрийг албажуулах бүрэлдэхүүн томилох тухай 793 захирамж гарчээ. Мөн тайлангийн хугацаанд шүүхийн тогтоол 110, мэдэгдэх хуудас 197 гарсан байна.

Улсын дээд шүүхийн хяналтын шатны Эрүүгийн хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаанаар хянан шийдвэрлэгдсэн 9 хэргийн 88.9 хувь буюу 8 хэргийн хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол, шүүгчийн захирамжийг хэвээр үлдээж, гомдлыг хэрэгсэхгүй болгож, 11.1 хувь буюу 1 хэргийн хяналтын шатны шүүх хуралдааны тогтоолыг хүчингүй болгожээ.

Улсын дээд шүүхийн хяналтын шатны Эрүүгийн хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаанаар шийдвэрлэсэн 9 хэргийг ялтан, түүний өмгөөлөгчийн гомдлоор хэлэлцжээ.




2.2. ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМ



ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМ

Иргэний хэргийн танхим өмнөх оны үлдэгдэл 38 хэрэг дээр хяналтын шатны журмаар 912, Хяналтын шатны шүүхийн тогтоолд Ерөнхий шүүгчид гомдол гаргасан 97, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай хүсэлт 74, нийт 1120 хэрэг хүлээн авч, 846 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, Хяналтын шатны шүүхийн тогтоолд Ерөнхий шүүгчид гомдол гаргасныг танилцуулж албан бичгээр 86 хэрэгт хариу өгч, 76 хэргийн шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай хүсэлтийг шүүх хуралдаанаар хэлэлцэж, 76 хэргийг хяналтын журмаар хэлэлцэхээс татгалзаж, 20 хэргийн харьяаллыг тогтоож, нийт 16 хэргийн үлдэгдэлтэй байгаагаас 11 хэргийг Ерөнхий шүүгчийн ажлын албанд шилжүүлж, 5 хэргийн үлдэгдэлтэй байна.

Нийт хүлээн авсан 1120 хэргээс



Иргэний хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдаанаар нийт 56 өдөр хуралдаж, өдөрт дунджаар 16 хэрэг хэлэлцжээ.

Иргэний хэргийн танхимд хяналтын шатны журмаар ирүүлсэн 998 хэргээс нэг шүүгчид 199 хэрэг тус тус ногдож байна.

Хяналтын журмаар хэлэлцэгдсэн иргэний 846 хэргийн 56.6 хувь буюу 479 хэргийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхиж, 7.6 хувь буюу 64 хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцааж, 22.2

хувь буюу 188 хэргийн шийдвэр, магадлалд нэмэлт, өөрчлөлт оруулж, 9.2 хувь буюу 78 хэргийн магадлалыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчилж, 4.4 хувь буюу 37 хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон байна.


Өөрчлөлт оруулсан 188 шийдвэр, магадлалын 61.7 хувь буюу 116 нь хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хууль хэрэглэсэн, хууль буруу тайлбарлаж хэрэглэсэн, 38.3 хувь буюу 72 нь шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн үндэслэлээр шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулжээ.

Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож хэргийн дахин хэлэлцүүлэхээр буцаасан 64 хэргийн 40.6 хувь буюу 26 хэргийг шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй гэж, 59.4 хувь буюу 38 хэргийг шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн үндэслэлээр шийдвэр, магадлалыг тус тус хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаажээ. Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг буюу хэргийг хэрэгсэхгүй болгосон 37 хэргийн 32.4 хувь буюу 12 нь шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, 67.6 хувь буюу 25 нь зохигчид эвлэрсэн байна.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах тухай 76 хүсэлтийн 74 хэргийн хүсэлтийг хангаагүй, 2 хэргийн хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн байна.

Хяналтын журмаар Танхимын тэргүүн Х.Сонинбаяр 18, Шүүгч Х.Эрдэнэсүвд 228, Г.Алтанчимэг 227, П.Золзаяа 227, Б.Ундрах 226 хэрэг хүлээн авчээ.

Шүүгч тус бүрийн хүлээн авсан хэрэг:




Хяналтын шатны Иргэний хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн Х.Сонинбаяр 921, шүүгч Г.Алтанчимэг 921, П.Золзаяа 921, Б.Ундрах 921, Х.Эрдэнэсүвд 921, Г.Цагаанцоож 2, Д.Цолмон 2 удаа оролцсоноос;

Танхимын тэргүүн Х.Сонинбаяр 903, шүүгч П.Золзаяа 8, Г.Алтанчимэг 4, Б.Ундрах 3, Х.Эрдэнэсүвд 3 хуралдааныг даргалж;

Танхимын тэргүүн Х.Сонинбаяр 17, шүүгч Г.Алтанчимэг 228, Б.Ундрах 227, П.Золзаяа 226, Х.Эрдэнэсүвд 223 хэргийг илтгэсэн байна.

**Иргэний хэргийн танхимын шүүгчдийн
2020 оны бүтэн жилийн ажлын ачаалал:**



Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн 34.3 хувь буюу 290 нэхэмжлэгчийн, 63.8 хувь буюу 540 хариуцагчийн, 1.8 хувь буюу 15 гуравдагч этгээдийн, 0.1 хувь буюу 1 прокурорын гомдлоор хянан хэлэлцэгджээ.

Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн 846 хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл:

Иргэний хуулиар 370, Хөдөлмөрийн тухай хуулиар 295, Гэр бүлийн тухай хуулиар 19, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар 148, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар 4, бусад хуулиар 10 хэргийг хянан шийдвэрлэжээ.

Мөн энэ хугацаанд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээс хяналтын журмаар гаргасан гомдолд нийт 805 446 079 /Найман зуун таван сая дөрвөн зуун дөчин зургаан мянга далан ес/ төгрөгийг улсын тэмдэгтийн хураамжид төлсний 198 128 426 /Нэг зуун ерэн найман сая нэг зуун хорин найман мянга дөрвөн зуун хорин зургаа/ төгрөгийг буцаан олгожээ.

Тус танхим 2020 оны эхний хагас жилд нийт 113 албан бичиг, 90 өргөдөл, гомдол хүлээн авснаас Танхимын тэргүүн Х.Сонинбаяр 86 албан бичиг, 74 өргөдөл, гомдол, шүүгч П.Золзаяа 15 албан бичиг, 2 өргөдөл, гомдол, Г.Алтанчимэг 2 албан бичиг, 3 өргөдөл гомдол, Б.Ундрах 5 албан бичиг, 5 өргөдөл, гомдол, Х.Эрдэнэсүвд 4 албан бичиг, 1 өргөдөл, гомдол тус тус хянан шийдвэрлэж, одоо 1 албан бичиг, 5 өргөдөл, гомдлын үлдэгдэлтэй байна.

Иргэний хэргийн танхим 2020 онд Улс төрийн намын бүртгэлийн талаар дараах ажлыг хийжээ. Үүнд:

- Үйлдвэрчний эв нэгдэл намыг 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж;
- Монголын Үндэсний Сэргэн мандал намыг 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 02 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж,
- Ард түмний олонхийн засаглал намын даргын өөрчлөлтийг 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 03 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж,
- Шударга иргэдийн нэгдсэн эвсэл намын дүрмийн өөрчлөлтийг 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор улсын бүртгэлд бүртгэж,
- Үйлдвэрчний Эв нэгдлийн намыг 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 05 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж,
- Ардчилал шинэчлэлийн намыг 2020 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 06 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж,
- Ард түмний олонхийн засаглал намын дүрмийн өөрчлөлтийг 2020 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 07 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж,
- Иргэний хөдөлгөөний намын дүрмийн өөрчлөлтийг 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 08 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж,
- Ардчилал шинэчлэлийн намыг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 09 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэж,
- Их эргэн сэргэлтийн үндэсний намыг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 10 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж,
- Ард түмний олонхийн засаглал намын даргын өөрчлөлтийг 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 11 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж,
- Ард түмний олонхийн засаглал намын даргын өөрчлөлтийг 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 12 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэж,
- Их эв намын дүрмийн өөрчлөлтийг 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 13 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэж тус тус шийдвэрлэсэн байна.

Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний болон шүүгчийн захирамж 1268 гаргаснаас Танхимын тэргүүний “Шүүх бүрэлдэхүүн томилох тухай” 986, харьяалал тогтоосон 20, “Улсын тэмдэгтийн хураамж буцааж олгох тухай” 186, “Гомдол

хэлэлцүүлэхээс татгалзах тухай” 2, “Гомдол гаргаагүйд тооцох тухай” 74 шүүгчийн захирамж тус тус гарчээ.




2.3. ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМ

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМ

Захиргааны хэргийн танхим 2019 оны үлдэгдэл 32 хэрэг дээр 2020 онд хяналтын шатны журмаар захиргааны 583 хэрэг, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах тухай хүсэлт 31, Мэргэжлийн хариуцлагын хорооны шийдвэрт гаргасан гомдолтой 8, тусгай журмаар хянан шийдвэрлэсэн буюу давж заалдах шатны шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргасан 13, анхан шатны журмаар 1 нэхэмжлэл нийт 668 хэргийг хүлээн авч, 437 хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар, 29 хэргийн шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах тухай хүсэлтийг шүүх хуралдаанаар хэлэлцэж, 54 хэргийн гомдлыг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамжид гомдол гаргасныг хянан хэлэлцэж, 1 нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, 113 хэргийг хуралдаанд оролцуулахгүйгээр шийдвэрлэж, одоо 34 хэргийн үлдэгдэлтэй байна.

Хяналтын шатны шүүхийн 135 тогтоолд Ерөнхий шүүгчид гомдол гаргасныг ажлын албанаас 130 хариу өгч, 5 хэргийн үлдэгдэлтэй байна.

Нийт хүлээн авсан захиргааны 803 хэргээс:



Захиргааны хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдаан нийт 72 өдөр хуралдаж, өдөрт дунджаар 7 хэрэг хэлэлцжээ.

Захиргааны хэргийн танхимд хяналтын шатны журмаар ирүүлсэн 668 хэргээс нэг шүүгчид 95 хэрэг ногдож байна.

Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэгдсэн 437 хэргийн 68.4 хувь буюу 299 хэргийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхиж, 10.5 хувь буюу 46 хэргийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, 21 хувь буюу 92 хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгожээ.


Шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон 92 хэргийн 50 хувь буюу 46 хэргийн магадлалыг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчлөлт оруулж, 28.2 хувь буюу 26 хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан болон давж заалдах шатны шүүхэд буцааж, 21.7 хувь буюу 20 хэргийн нэхэмжлэлийг болон хэргийг хэрэгсэхгүй болгох, эсхүл нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн байна.

Шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулсан 46 хэргийн 32.6 хувь буюу 15 хэргийг шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, 30.4 хувь буюу 14 хэргийн шийдвэр, магадлалыг бусад, 36.9 хувь буюу 17 хэргийг хууль буруу хэрэглэсэн үндэслэлээр тус тус өөрчлөлт оруулжээ.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлттэй 29 хэргийн 27 хэрэгт хүсэлтийг хангахгүй орхиж, 2 хэргийн хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн байна.

Хяналтын журмаар шүүгч Д.Мөнхтуяа 132, Г.Банзрагч 130, Б.Мөнхтуяа 129, М.Батсуурь 95, Ч.Тунгалаг 72, П.Соёл-Эрдэнэ 64, Х.Батсүрэн 46 захиргааны хэрэг тус тус хүлээн авчээ.

Шүүгч тус бүрийн хүлээн авсан хэрэг:



Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанд Г.Банзрагч 311, Д.Мөнхтуяа 261, Б.Мөнхтуяа 241, М.Батсуурь 186, П.Соёл-Эрдэнэ 160, Ч.Тунгалаг 139, Х.Батсүрэн 100 удаа оролцсоноос;

Танхимын тэргүүн Ч.Тунгалаг 244, шүүгч М.Батсуурь 136, Д.Мөнхтуяа 43, Х.Батсүрэн 19, Б.Мөнхтуяа 18, Г.Банзрагч 5, П.Соёл-Эрдэнэ 1 хэргийн шүүх хуралдааныг даргалж;


Шүүгч Б.Мөнхтуяа 92, Д.Мөнхтуяа 91, Г.Банзрагч 89, Ч.Тунгалаг 58, М.Батсуурь 56, П.Соёл-Эрдэнэ 51, Х.Батсүрэн 29 хэрэг илтгэсэн байна.

Гомдлыг хүлээн авахаас татгалзсан захирамж хэлэлцэх шүүх хуралдаанд шүүгч Г.Банзрагч 17, Д.Мөнхтуяа 12, Б.Мөнхтуяа 11, М.Батсуурь 9, П.Соёл-Эрдэнэ 4, Ч.Тунгалаг 4 удаа оролцсоноос;

Шүүгч Х.Батсүрэн 16, Б.Мөнхтуяа 16, Д.Мөнхтуяа 9, П.Соёл-Эрдэнэ 7, М.Батсуурь 6, Ч.Тунгалаг 2, Г.Банзрагч 1 хэргийн шүүх хуралдааныг даргалж;

Шүүгч Б.Мөнхтуяа 11, Г.Банзрагч 10, Д.Мөнхтуяа 10, М.Батсуурь 9, П.Соёл-Эрдэнэ 7, Х.Батсүрэн 5, Ч.Тунгалаг 5 хэрэг илтгэсэн байна.

**Захиргааны хэргийн танхимын шүүгчдийн
2020 оны бүтэн жилийн ажлын ачаалал:**



Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн 44.0 хувь буюу 192 итгэмжлэгдсэн төлөөлөгчийн, 18.7 хувь буюу 82 нэхэмжлэгчийн, 11.6 хувь буюу 51 өмгөөлөгчийн, 8.6 хувь буюу 38 хариуцагчийн, 3.2 хувь буюу 14 гуравдагч этгээдийн, 13.7 хувь буюу 60 гомдол гаргагчийн гомдлоор хянан хэлэлцжээ.

Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн 437 хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл:

Газрын маргаан 81, Зөрчлийн маргаан 80, Төрийн албаны маргаан 62, Татварын маргаан 54, Ашигт малтмалын маргаан 34, төрийн болон орон нутгийн өмчийн тухай маргаан 16, мэргэжлийн хариуцлагын хорооны 5, бусад 105 хэргийг тус тус хянан шийдвэрлэжээ.

Мөн хугацаанд иргэн, хуулийн этгээдээс хяналтын журмаар гаргасан гомдолд нийт 31,098,600 /гучин нэгэн сая ерэн найман мянга зургаан зуун мянга/ төгрөгийг улсын тэмдэгтийн хураамжид төлсний 4,352,400 /дөрвөн сая гурван зуун тавин хоёр дөрвөн зуун/ төгрөгийг буцаан олгожээ.

Захиргааны хэргийн танхим 2020 онд нийт 23 албан бичиг, 9 өргөдөл, гомдол хүлээн авснаас Танхимын тэргүүн Ч.Тунгалаг 10 албан бичиг, 2 өргөдөл гомдол, шүүгч М.Батсуурь 5 албан бичиг, 1 өргөдөл гомдол, Д.Мөнхтуяа 2 албан бичиг, 1 өргөдөл гомдол, Б.Мөнхтуяа 2 албан бичиг, 1 өргөдөл, гомдол, П.Соёл-Эрдэнэ 2 албан бичиг, Г.Банзрагч 1 албан бичиг, 2 өргөдөл гомдол, Х.Батсүрэн 2 өргөдөл гомдолд хариу өгч, одоо 1 албан бичгийн үлдэгдэлтэй байна.

Тайлангийн хугацаанд шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол бүгд 998 гаргаснаас Танхимын тэргүүний захирамж “бүрэлдэхүүн томилох тухай” 85, “хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай” 457 захирамж, “шүүх хуралдааныг хойшлуулах тухай” 195 тогтоол, захирамж, “гомдлыг хүлээн авахаас татгалзах тухай” 100 захирамж, “гомдол хүлээн авахаас татгалзсан захирамжийг хянасан” 54 тогтоол, “улсын тэмдэгтийн хураамж буцаан олгох тухай” 60 захирамж, “шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлтийг шийдвэрлэх тухай” 29 тогтоол, “гомдол гаргаагүйд тооцох тухай” 8, бусад 10 захирамж, тогтоол гаргажээ.

ГУРАВ. ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНААС БУСАД АЖЛЫН ТАЛААР

3.1. Улсын дээд шүүхийн шүүгчдийн зөвлөгөөн 2 удаа хуралдаж дараах асуудлыг хэлэлцжээ. Үүнд:

1. 2020 оны 03 дугаар сарын 24-ний өдөр хуралдаж “Олон Улсын Эрүүгийн шүүхийн шүүгчид нэр дэвшүүлэх тухай” асуудлыг хэлэлцэж, шүүгч Ч.Хосбаярыг Олон Улсын Эрүүгийн шүүхийн шүүгчид нэрийг дэвшүүлсэн байна.
2. 2020 оны 05 дугаар сарын 22-ны өдөр хуралдаж “Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид нэр дэвшүүлэх тухай” асуудлыг хэлэлцэж, шүүгч Д.Ганзоригийг Ерөнхий шүүгчээр томилуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид санал болгожээ.

3.2. Улсын дээд шүүх нь:

- “Төрийн хяналт шалгалтын тухай” /шинэчилсэн найруулга/;
- “Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай”;
- “Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай”;
- “Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай”;
- “Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай”;
- “Хуульчийн эрх зүйн байдлын тухай” /шинэчилсэн найруулга/;
- “Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”;
- “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”;
- “Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”;
- “Хууль зүйн туслалцааны тухай” /шинэчилсэн найруулга/;
- “Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль” /шинэчилсэн найруулга/;
- “Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай” /шинэчилсэн найруулга/ хууль;
- “Төрийн мэдээлэл солилцооны хур системээс цахим хэлбэрээр лавлагаа, мэдээлэл авах журам”;
- “Нөлөөллийн мэдүүлгийг шийдвэрлэх журам”-ын төслүүдэд тус тус санал өгч ажилласан байна.

3.3.Бусад

1. Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Б.Цогт “Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс”-ын гишүүнээр,

2. Захиргааны хэргийн танхимын тэргүүн Ч.Тунгалаг, шүүгч Г.Алтанчимэг, С.Батдэлгэр, Д.Эрдэнэбалсүрэн нар 2020 оны 1 улиралд Шүүхийн тухай хуулийн ажлын хэсгийн гишүүнээр,

3. Шүүгч Д.Эрдэнэбалсүрэн “Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл”-ийн гишүүнээр;

4. Шүүгч Г.Алтанчимэг “Монголын нотариатчдын мэргэшлийн хороо”-ны гишүүнээр;

5. Шүүгч Ч.Хосбаяр “Санхүүгийн арга хэмжээ авах байгууллага” (ФАТФ)-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай орны жагсаалтаас Монгол Улсыг гаргах ажлын хэсгийн болон “Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх тогтолцооны үндэсний эрсдэлийн үнэлгээ”-ний Дэд ажлын хэсгийн гишүүнээр;

6. Шүүгч Б.Амарбаясгалан, Б.Батцэрэн, Ч.Хосбаяр, Д.Эрдэнэбалсүрэн нар Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсгийн гишүүнээр;

7. Шүүгч Б.Батцэрэн Шүүхийн мэргэшлийн хорооны даргаар;

8. Шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Х.Эрдэнэсүвд нар Шүүхийн мэргэшлийн хорооны гишүүнээр,

9. Шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч нар Монголын Хуульчдын холбооны Хуульчдын мэргэжлийн шалгалтын хорооны гишүүнээр;

10. Шүүгч Д.Мөнхтуяа, Ц.Цогт, Б.Ундрах, Д.Эрдэнэбалсүрэн, Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Амардэлгэр нар Шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх чиг үүргийн хүрээнд байгуулагдсан дэд ажлын хэсгийн гишүүнээр тус тус ажилласан байна.

Сургалт, уулзалт-ярилцлагууд:

Улсын дээд шүүхийн Танхимын тэргүүн, шүүгчид дараах сургалт, уулзалт ярилцлагыг зохион байгуулах, оролцох, хичээл заах хэлбэрээр ажиллажээ. Тухайлбал:

- Танхимын тэргүүн Б.Цогт, шүүгч Б.Батцэрэн, Ч.Хосбаяр, Д.Эрдэнэбалсүрэн нар Эрүүгийн эрх зүйн сургагч багшаар;

- Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим, Төрийн албаны зөвлөл, Нэгдсэн Үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төсөлтэй хамтран 2020 оны 11 дүгээр сарын 09, 10-ны өдрүүдэд зохион байгуулсан “Захиргааны хууль тогтоомжийн хэрэглээний нэгдмэл чанар, шүүхийн практик” сургалтад Танхимын тэргүүн Ч.Тунгалаг оролцсон,

- дээрх сургалтад шүүгч Г.Банзрагч “Захиргааны гэрээний маргааныг шүүхээс хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдвээр,

-Шүүгч М.Батсуурь “Зөрчлийн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд анхаарах асуудал, хууль хэрэглээ” сэдвээр,

-Шүүгч Д.Мөнхтуяа “Шүүхээс татварын хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд анхаарах асуудал, хууль хэрэглээ” сэдвээр тус тус хичээл заажээ.

- Мөн шүүгч Г.Банзрагч Монголын Хуульчдын холбооноос 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулсан Хуульчдын үргэлжилсэн багц цагийн сургалтад “Захиргааны хэргийн шүүхэд гаргах нэхэмжлэлийн төрөл” сэдвээр;

- Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхим, Германы Олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах төсөл”-тэй хамтран 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдрөөс 11 дүгээр сарын 04-ний өдрийг хүртэлх хугацаанд 4 ээлжээр зохион байгуулсан “Хуульд зааснаар болон зөрчлийн улмаас үүсэх үүрэг ба иргэний хуулийн хэрэглээ” сэдэвт сургалтад шүүгч П.Золзаяа 3 өдөр хичээл заажээ.



ДӨРӨВ. ТАМГЫН ГАЗРЫН АЖЛЫН ТАЛААР

4.1. ШҮҮХИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГА

4.1.1. Шүүгчийн хараат бус байдлыг хангах чиглэлээр: Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулиар шүүгч албан үүргээ гүйцэтгэх явцад амь нас, эрүүл мэндэд нь хохирол учирсан тохиолдолд даатгалын бусад төрлөөс үл хамааран олгогдох заавал даатгагдах албан журмын даатгалын төрлийг хуульчлан тусгасан. Хуулийн дээрх заалтын хэрэгжилтийг зохион байгуулж, холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу “Ард даатгал” ХК-тай “Шүүгчийн амь нас, эрүүл мэндийн даатгал”-ын гэрээг байгуулан эрсдэлээс хамгаалан ажиллаж байна.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор иргэд болон хэргийн оролцогч нарыг зөвхөн “Б” байрны хаалгаар нэвтрүүлж, Төрийн тусгай хамгаалалтын газрын шалган нэвтрүүлэгч хөдөлгөөнд нь хяналт тавин ажиллаж байна. Мөн шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд ачаа тээш шалгах, хадгалах рентген аппарат, металл илрүүлэгч хаалга, металл хайгч гар багажуудыг Мэргэжлийн хяналтын газраас зохих зөвшөөрөл авч Улсын Дээд шүүхийн төв хаалганд байршуулж, мөн локор байрлуулсан.

Шүүн таслах ажиллагааны аюулгүй байдал хариуцсан шинжээч, цагдаагийн албатай хамтран шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг ханган, шүүн таслах ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэн, хяналтын шатны шүүх хуралдаануудад журам сахиулан ажилласан байна. Эрүүгийн хэргийн танхим 820, иргэний хэргийн танхим 990, захиргааны хэргийн танхим 681 шүүх хуралдаан тус тус явуулсанаас эрүүгийн хэргийн 155, иргэний хэргийн 2, захиргааны хэргийн 1, нийт 158 шүүх хуралдаан хуульд заасан журмын дагуу хаалттайгаар хуралджээ.

Мөн хугацаанд М.Сономпил, Б.Амархүү, Н.Баярсайхан, Б.Хурц, М.Энхсайхан, Б.Махбал, Э.Оюунболд, Г.Солтан нарт холбогдох эрүүгийн хэрэг, “Ноён уулаа аврах НҮТББ” нэхэмжлэлтэй, Ашигт малтмал, газрын тосны газарт холбогдох /шинээр илэрсэн нөхцөл байдал/ захиргааны хэрэг, Н.Энхбаярын нэхэмжлэлтэй, Сонгуулийн ерөнхий хороо, Цагдаагийн ерөнхий газарт холбогдох захиргааны хэрэг, намуудын бүртгэл, хүсэлт зэргийг шийдвэрлэсэн онцлох шүүх хуралдаанууд болж өнгөрсөн байна.



Тайлангийн хугацаанд 197 мэдэгдэх хуудас Цагдаагийн Ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт хүргэгдсэнээс, 8 шүүгдэгчийг шүүхийн байрнаас хуяглан, цагдаагийн албан хаагчид хүлээлгэн өгч ажилласан байна.

4.1.2.Шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах чиглэлээр: Тамгын газрын дарга 2020 онд хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн нийт 161 тушаал, үүнээс үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 57, хүний нөөцийн удирдлагын чиглэлээр 104 тушаал тус тус гаргажээ.

Тайлангийн хугацаанд дараах журам, дүрэм, хөтөлбөр, төлөвлөгөөг судалж, боловсруулах, батлуулан хэрэгжүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:


- “Монгол Улсын дээд шүүхийн 2019-2023 оны стратеги төлөвлөгөө”-ний төсөл;
- “Орон сууцны дэмжлэг олгох” журам;
- “Монгол Улсын дээд шүүх”, “Дээд шүүхийн мэдээлэл”, “Монголын төр эрх зүй” сэтгүүлүүдийг эрхлэн гаргах журмын төсөл;
- “Улсын дээд шүүхийн төрийн захиргааны ажилтнуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, түүний үр дүн, хөдөлмөрийн гэрээний биелэлтийг тооцож, мөнгөн урамшуулал олгох” журам;
- Шүүх хуралдааны аюулгүй байдлыг хангах зорилгоор аюулгүйн үзлэг шалгалтад ашиглаж буй рентген төхөөрөмжийн “Цацрагийн аюулгүй ажиллагааны дотоод дүрэм”, “Цацрагийн хамгаалалтын хөтөлбөр”, “Цацрагийн болзошгүй ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөө”;
- Дотоод аудитын эрсдэлд суурилсан 2020 оны төлөвлөгөө;
- Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2019 оны санхүүгийн аудитын тайланд өгөгдсөн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө;

- Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий прокурор, Сангийн сайдын хамтарсан захирамж, тушаалаар баталсан “Барьцааны мөнгө байршуулах, шилжүүлэх, шийдвэрлэх журам”;
- Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн баталсан “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлын үед шүүгчийг 24 цагаар ажиллуулах журам”;
- Улсын дээд шүүхийн Тамгын газрын даргын баталсан “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед хяналтын шатны шүүхийн ажиллах түр журам” зэрэг болно.


Авлигын эсрэг хууль, “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-д заасны дагуу шүүгч, захиргааны албан хаагчдаас “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг”-ийг 2019 оны байдлаар шинэчлэгдсэн маягтын дагуу дахин гаргуулан авч, 22 шүүгчийн материалыг Шүүхийн Ерөнхий зөвлөлд, 48 захиргааны албан хаагчийн материалыг Тамгын газарт зохих журмын дагуу хадгалж, цахим хэлбэрээр шинэчлэн гаргасан байна.

2020 оны байдлаар 492 өргөдөл гомдол, 1906 албан бичиг, 4392 хавтаст хэрэг хүлээн авч, зохих журмын дагуу бүртгэн, бүртгэл хяналтын карт нээж, уг албан бичгүүдийг Ерөнхий шүүгч, Тамгын газрын даргад танилцуулсны дагуу шүүгч, ажилтнуудад хуваарилан өгч шийдвэрлүүлснээс гадна 5146 албан бичигт дугаар өгч холбогдох шүүх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлжээ.

Бичиг хэргийн эргэлтийг өмнөх онтой харьцуулбал:



Улсын дээд шүүхийн бичиг хэргийн эргэлтийг сайжруулах, ажлын хариуцлага, бүтээмж, эмх цэгцийг дээшлүүлэх, цахим бичиг хэрэг, архивын систем нэвтрүүлэх зорилгоор “Цахим оффис”-ын нэгдсэн системийг 12 дугаар сараас эхлэн үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.



Сүлжээний эцсийн хэрэглэгчийн аюулгүй байдлыг хангах үүднээс албан ёсны эрхтэй “Касперски” програм хангамжийг ашиглаж байгаа бөгөөд интернетын урсгалыг Төрийн мэдээлэл холбооны хамгаалалттай сүлжээгээр дамжуулан ашиглаж байна. Мөн Улсын дээд шүүхэд ашиглаж байгаа бүх сервер компьютерууд албан ёсны лицензтэй, үйлдлийн системтэй боллоо.

Аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран ажиллах гэрээнд хууль зүйн дүгнэлт санал өгч ажиллаж байна. Тухайлбал:

- Автомашины граж түрээслэх гэрээ;
- Зураг төсөл боловсруулах гэрээ;
- Хөлсөөр ажиллах гэрээ;
- Худалдах, худалдан авах гэрээ;
- Цахим оффис болон антивирусын програм хангамжийн гэрээ;
- “Windows server” үйлдлийн системийн лицензийн гэрээ;
- Автомашины даатгалын гэрээ; зэрэг болно.

Монгол Улсад коронавирус /COVID-19/-ын халдвар бүртгэгдэж, улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан, уг халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор Улсын дээд шүүхийн шүүгчид, Тамгын газрын ажилтнуудын ажиллах

цагийн хуваарийг 10.00-16.00 цагийн хооронд болгон өөрчилж, ажлын тусгай горимд шилжүүлэн ажиллав.

Мөн 0-12 насны хүүхэдтэй, жирэмсэн эмэгтэй шүүгч, ажилтнуудад өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд цалинтай чөлөө олгож, албан ажилдаа ирэлгүйгээр, гэрээсээ цахим хэлбэрээр, утсаар, и-мэйлээр ажил үүргийг нь гүйцэтгүүлэх нөхцөл боломжоор хангаж ажиллалаа.

“Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед хяналтын шатны шүүхийн ажиллах түр журам” батлан хэрэгжүүлж байгаатай холбогдуулан 2020 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн Zoom технологи ашиглан хэргийн оролцогчдыг өөрсдийн байгаа газраас шүүх хуралдаанд оролцох боломжийг бүрдүүлэн хяналтын шатны шүүх хуралдааныг явуулж эхлээд байна. Үүний зэрэгцээ, түр журамд заасны дагуу өргөдөл, гомдол хүлээн авах, хэргийн материалтай танилцах, шүүх хуралдаанд Zoom технологи ашиглан оролцох хэлбэрийг олон нийтэд энгийн, ойлгомжтой хүргэх зорилгоор богино хэмжээний 3 хөдөлгөөнт видео танилцуулгыг өөрийн цахим хуудсаар мэдээлж, YouTube.com гэх зэрэг бусад нийгмийн сүлжээнд байршуулав.



Хөдөлгөөнт видео танилцуулга

[/www.supremecourt.mn/](http://www.supremecourt.mn/)

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д “Хуульч хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсны дараа шүүхэд төлөөлөх эрх нээлгэхээр Улсын дээд шүүхэд бүртгүүлж...өмгөөлөгчийн нэрсийн жагсаалтад бүртгэгдэнэ.” гэж заасны дагуу Тамгын газрын даргын тушаалаар энэ онд 109, нийт 3251 хуульчдад өмгөөлөгчийн шүүхэд төлөөлөх эрхийг тус тус нээж, гэрчилгээ, үнэмлэх олгосон.

Мөн Өмгөөллийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан түүнийг дагаж мөрдөх журмын тухай хуульд заасны дагуу шүүхэд төлөөлөх эрх нээлгэсэн хуульчдын бүртгэлийг Монголын Өмгөөлөгчдийн холбоонд 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр шилжүүлж хүлээлгэн өгсөн байна.

Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Танхимын тэргүүн, шүүгчид, Тамгын газрын дарга нар тус шүүхэд ажиллаж байгаад гавъяаныхаа амралтад гарсан ахмадуудаа жил бүр хүлээн авч хүндэтгэл үзүүлдэг бөгөөд энэ жил Цагаан сар, Ахмадын баярын өдрүүдийг тохиолдуулан хүндэтгэл үзүүллээ.

4.1.3 Хүний нөөцийн чиглэлээр: Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 77 дугаар зарлигаар Д.Ганзоригийг Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчээр, 2019 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн 238 дугаар зарлигаар Б.Амарбаясгаланг Монгол Улсын дээд шүүхийн шүүгчээр, 2020 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 104 дүгээр зарлигаар Ч.Тунгалагийг Монгол Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүнээр, 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 144 дүгээр зарлигаар Ц.Цогтыг Монгол Улсын Дээд шүүхийн шүүгчээр тус тус томиллоо.



Зураг дээр: Ерөнхий шүүгч Д.Ганзориг

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2020 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 99 дүгээр тогтоолоор Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Захиргаа удирдлагын хэлтсийн дарга С.Амардэлгэрийг томилов.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 42 дугаар зарлигаар Ерөнхий шүүгчийн туслах-референт Б.Бямбаабаатарыг Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчээр, Танхимын тэргүүний туслах-ахлах шинжээч Э.Энхжаргалыг Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчээр, Хууль тогтоомжийн системчлэл хариуцсан ахлах мэргэжилтэн М.Далайхүүг Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчээр тус тус томилсон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 24, 472 дугаар тогтоолуудаар албан тушаалын цалингийн сүлжээг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор албан хаагчдын үндсэн цалинг шинэчлэн тогтоож, мөн Тамгын газрын даргын тушаалаар 27 хүнд төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, 3 хүнд ур чадварын нэмэгдэл шинээр болон нэмэгдүүлэн олголоо.

Тайлант онд Улсын дээд шүүхийн шүүгч Б.Ундрах “Шударга ёсны элч” тэмдгээр, бичиг хүргэгч Б.Уртнасан, үйлчлэгч Д.Оюунцэцэг нар “Хөдөлмөрийн хүндэт” медалиар тус тус шагнагдсан бол улсад 37 жил, үүнээс Улсын дээд шүүхэд 31 жил тасралтгүй ажилласан үйлчлэгч Д.Загдсүрэн өндөр насны тэтгэвэр тогтоолгов.



Тайлбар: Зураг дээр арын эгнээний зүүн гар талаас С.Бурмаа, Н.Булгамаа, С.Амардэлгэр, ерөнхий шүүгч Д.Ганзориг, Д.Тулга. Урд эгнээний зүүн гар талаас Д.Алтанцэцэг, Д.Загдсүрэн, Д.Оюунцэцэг, Б.Уртнасан, Д.Мөнгөнцэцэг, Р.Ганпүрэв нар.

Түүнчлэн, Тамгын газраас 2020 оны 10 дугаар Шүүхийн ерөнхий зөвлөлд санал хүргүүлэн ажилласнаар “Хэргийн хөдөлгөөн хариуцсан референт-1”, “Ерөнхий шүүгчийн ажлын албаны туслах-шинжээч-1” бүгд хоёр орон тоо нэмэгдүүлж, эдгээр албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах ажлыг хийж байна.

Өнгөрсөн онд шүүхийн сургалтын хөтөлбөр боловсруулах, шүүхийн хүний нөөцийн чадавхыг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж, шүүхийн захиргааны ажилтныг дэмжих ажлын хүрээнд сургалтын агуулгыг шинэчлэх, орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх, шинээр батлагдсан хууль тогтоомжийн агуулгыг таниулах, хууль хэрэглээний чадвар олгох зорилт тавьж, хэрэгжүүлж ажиллалаа.

Тухайлбал, Төрийн албаны тухай хууль шинэчлэн батлагдан хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан “төрийн албаны мэргэшсэн, тогтвортой, ил тод, хариуцлагатай байх эрх зүйн үндсийг бүрдүүлэх, төрийн албаны төв байгууллага, төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, нийгмийн баталгааг тогтоох” зорилтын хүрээнд тэргүүн түшмэл, эрхэлсэн түшмэл, ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан хаагчид Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Удирдлагын академи, Нэгдсэн Үндэстний Байгууллагын хамтран зохион байгуулсан “Мэргэшүүлэх багц сургалт” сэдэвт сургалтад хамрагдаж, сертификатаа гардаж авлаа.

Мөн Мэдээллийн технологи хариуцсан референт Э.Баярбаатарыг төрийн захиргааны байгууллагын зөвшөөрсөн тусгай хөтөлбөрийн дагуу явагдах цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын сургалтад;

Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг тогтмолжуулах, мэдээллийн аюулгүй байдлын тухай мэдлэг программ, техник хангамж, практикийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Компьютерын техник хангамжийн ажил хариуцсан ахлах шинжээч Ж.Эрдэнийг “Шүүхийн мэдээллийн технологийн мэргэжилтнүүд”-ийн сургалтад тус тус хамрууллаа.

4.1.4. Архивын ажлын чиглэлээр: Улсын дээд шүүхийн архивын баримтын хадгалалт, хамгаалалтын стандартыг хангасан техник, тоног төхөөрөмжөөр хангах зорилтыг дэвшүүлэн ажиллалаа.

Тус шүүхийн архив нь 2020 онд батлагдсан Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Үндэсний архивын газрын даргын 2007 оны 59 дүгээр тушаалаар батлагдсан “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2019 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Иргэн, захиргааны хэргийн баримтын төрөлжсөн архивын ажлын заавар”, Улсын ерөнхий прокурор, Шүүхийн

ерөнхий зөвлөл, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны А/18, 34, А/31 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Эрүүгийн болон зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд холбогдох баримтыг архивт хадгалах заавар”, “Эрүүгийн хэргийн төв болон салбар архивт хадгалагдаж байгаа баримтыг хадгалах хугацааны заавар”-ыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Улсын дээд шүүхийн Байнга хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэлд 216 баримт, Түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэлд 182 баримт, 70 жил хадгалах хадгаламжийн бүртгэлд 5 баримт, нийт 403 баримтыг 2020 оны нэгдүгээр улиралд багтаан хүлээн авч, архивын нэгж үүсгэн хадгалж байна.

Архивын 2020 оны жилийн эцсийн тооллогын дүнгээр хадгаламжийн нэгж нь дараах төрөлд ангилагдаж байна. /хүснэгтээр харуулав/

д/д	Хадгаламжийн нэгж	Он	Хадгаламжийн нэгж
1.	Байнга хадгалах хадгаламжийн нэгжийн баримт	1996-2019	2118
2.	Түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл	1994-2019	1730
3.	70 жил хадгалах баримтын бүртгэл	1987-2019	57
4.	Дээд шүүх өөрийн эрхээр таслан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг	1974-2017	305
5.	Иргэний хэрэг	1974-2005	46
6.	Захиргааны хэрэг	2017	3
7.	Кино, гэрэл зураг, дуу, дүрсний баримт	1960-2019	4848
	БҮГД		9107

Байгууллагын дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комиссын хуралдаанаар байнга, түр болон 70 жил хадгалах 2013-2019 оны баримт бичгийн бүртгэлийг баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

4.1.5. Номын сангийн чиглэлээр: Тус шүүхийн номын сан нь Монгол, Англи, Герман хэл дээр улс төр, эрх зүйн онол, шүүх судлал, үндсэн хуулийн эрх зүй, эрүү, иргэн, захиргааны эрх зүй, хууль зүйн мэргэжлийн толь бичиг зэрэг 5967 ном, сэтгүүлийн фондтой болжээ.

“Өдрийн сонин”, “Өнөөдөр”, “Зууны мэдээ”, “Үндэсний шуудан”, “Монголын үнэн”, “Засгийн газрын мэдээ”, “Өглөөний сонин”, “Ардчилал таймс”, “Монголын

мэдээ” зэрэг 9 төрлийн сонин, “Төрийн мэдээлэл”, Дээд шүүхийн “Мэдээлэл”, “Монголын төр, эрх зүй”, “Хууль дээдлэх ёс” зэрэг 4 төрлийн сэтгүүлийг ангилан байрлуулж, уншигчдад үйлчилж байна.

4.1.6 Цагаатгалын бүртгэлийн чиглэлээр: Улсын дээд шүүхэд 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 12 дугаар сарын 25-ны өдрийн хооронд Улсын ерөнхий прокурорын газраас Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгуулахаар прокурорын дүгнэлтийг 12 удаа бичиж ирүүлсэн ба нийт 17 хэлмэгдэгчдийг цагаатгасан байна.

Хэлмэгдэгчдийн төрөл садангаас цагаатгуулах хүсэлт 9, нөхөн олговор олгох хүсэлт 18 тус тус ирснийг харьяаллын дагуу зохих байгууллагуудад шилжүүлсэн.

Энэ хугацаанд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийн цагаатгалын үнэмлэх олгох талаар хэлмэгдэгчдийн төрөл, садан болон Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссуудаар дамжуулан 156 өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, үүнээс цагаатгалын 53 үнэмлэх олгосноос шинээр 21 үнэмлэх, 32 үнэмлэх нөхөн олгожээ.

Улсын дээд шүүх улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн хэлмэгдэгчдийг БНМАУ-ын Дээд шүүх /1962-1990 он/, Монгол Улсын дээд шүүх /1990 оноос одоог хүртэл/ цагаатгаж байна. Энэ хугацаанд Монгол Улсын дээд шүүхээс 14675 хүнийг цагаатгасан байна.


Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор нөхөх олговор нэхэмжлэх хугацааг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгаж, улс төрийн хилс хэрэгт холбогдуулан цаазаар авах ялаар шийтгүүлсэн хэлмэгдэгчийн эхнэр /нөхөр/, эсхүл хэлмэгдэгчийн төрсөн болон үрчилж авсан хүүхдэд 80.0 сая төгрөг, хорих ялаар шийтгүүлсэн бол 40.0 сая төгрөгийн нэг удаагийн нөхөн олговор олгох эрх зүйн орчин бүрдсэнээр Улсын дээд шүүхэд хандах иргэдийн тоо өссөн үзүүлэлттэй байна.

4.2. ШҮҮХИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ


Шүүхийн зохион байгуулалтын хэлтэс нь шүүн таслах ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулах нөхцөлийг хангах ажлыг зохион байгуулан, шүүх хуралдааны танхим, техник, зохион байгуулалтын бэлтгэл болон шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангах, шүүх хуралдааны журам сахиулах, хяналтын шатны шүүх хуралдааны тов, тойм, хяналтын шатны шүүхийн тогтоолыг www.supremecourt.mn болон www.shuukh.mn цахим хуудсанд байршуулах, онлайн шүүх хуралдааны бэлтгэл хангах, шүүх хуралдааны явцыг дуу

болон дүрс бичлэгээр баталгаажуулах, шүүн таслах ажиллагааны сар, улирал, хагас, бүтэн жилийн тайлан мэдээ гарган холбогдох байгууллагад хүргүүлэх, хуульд заасан бусад чиг үүргийг гүйцэтгэхийн зэрэгцээ шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарын ажлын зохион байгуулалт, албан хэрэг хөтлөлт, хэргийн хөдөлгөөний аргачлал, цахим санд шүүхийн шийдвэр нийтлэх журмын хэрэгжилт, эрүү, иргэн, захиргааны хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системийн ашиглалтад тус тус хяналт тавин ажиллалаа.

Тайлангийн хугацаанд албан бичиг 31, өргөдөл, гомдол, хүсэлт 58-ыг зохих журмын дагуу тус тус хүлээн авч, судлан холбогдох албан тушаалтанд танилцуулан хуулийн хугацаанд шийдвэрлэж хариуг уламжилсан байна.



Мөн Ерөнхий шүүгчийн туслах-референтээс “хуулбар үнэн” тэмдэг дарж ирүүлсэн 429 албан бичиг, тогтоолын хуулбарт /бүртгэл хөтөлж/ Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн стандартын дагуу баталгаажуулалт хийсэн байна.



Улсын дээд шүүхийн вэб сайтад хяналтын шатны шүүх хуралдааны эрүүгийн 820, иргэний 990, захиргааны 681 зар, тоймыг тус тус байршуулсан байна.

Хяналтын шатны шүүх хуралдааны техник, зохион байгуулалтын бэлтгэлийг хангаж эрүүгийн 785, иргэний 882, захиргааны 572 хэргийн шүүх хуралдааны

тэмдэглэл хөтөлж, шүүх хуралдааны явцыг дуу болон дүрс бичлэгээр баталгаажуулан, шүүх хуралдааны тэмдэглэлийг ёсчлуулан хэргийн оролцогчдод хуульд заасан хугацаанд танилцуулж, бүртгэл хяналтын системд байршуулан, хэргийн материалд хавсаргажээ.

Хэргийн оролцогчдоос шүүх хуралдааны дуу, дүрс бичлэгийг хуулбарлан авахыг хүссэн 21 хүсэлтийг зохих журмын дагуу хүлээн авч, хүсэлтийг үндэслэн шүүх хуралдааны бичлэгийг хуулбарлан өгөх асуудлыг Тамгын газрын даргад танилцуулан, хүсэлт гаргагчид баталгааны хуудас /маягт/-т гарын үсэг зуруулан хүлээлгэн өгсөн байна.

“Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед хяналтын шатны шүүхийн ажиллах түр журам” батлан хэрэгжүүлж эхэлсэнтэй холбогдуулан 2020 оны 12 дугаар сараас эхлэн хяналтын шатны шүүх хуралдааныг алсын зай /онлайн/-аас явуулж, тайлангийн хугацаа дуусах хүртэл 192 шүүх хуралдааныг тухайн горимоор хийжээ.

Хяналтын шатны шүүхийн 2020 онд хянан шийдвэрлэсэн эрүү, иргэн, захиргааны хэргийн тогтоолуудыг www.shuukh.mn сайтад зохих журамд заасны дагуу байршуулан ажиллаж байгаагаас эрүүгийн 442, иргэний 667, захиргааны 330 тогтоол байна.

Тайлангийн хугацаанд Шүүхийн ерөнхий зөвлөлд:

-Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн №104 тоот “Хэргийн хөдөлгөөний удирдлагын талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын дагуу хяналтын шатны шүүхийн хэргийн хөдөлгөөний удирдлагын талаар авах арга хэмжээний тайлан;

- Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2020 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 01/333 тоот албан бичгийн дагуу Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэгдсэн хэрэгт бичигдсэн мэдэгдэх хуудасны талаарх мэдээллийн тайлан;

-Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2020 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 01/705 тоот албан бичгийн дагуу Шүүхийн шийдвэрийг нийтлэх журмын хэрэгжилтийг ханган ажиллах арга хэмжээний тайлан;

-Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2016 оны А/40, 113 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Шүүгч, шүүхийн аюулгүй байдлыг хангах журам” болон “Яллагдагчийг хуяглан хүргэх, албадан ирүүлэх, эрэн сурвалжлах ажиллагаа явуулах журам”-ын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох хууль, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах гэж байгаатай

холбогдуулан, хоёр журмын өөрчлөлтөд тусгах /хяналтын шатны шүүхийн шүүн таслах ажилд нэн шаардлагатай/ санал боловсруулан Тамгын газрын даргад танилцуулан тус тус хүргүүлсэн байна.

Мөн хугацаанд хяналтын шатны шүүхийн “Шүүхийн захиргааны хяналт-шинжилгээний сар тутмын мэдээ”-г administration@judcouncil.mn цахим хаягаар, шүүн таслах ажиллагааны улирал, хагас, бүтэн жилийн тайланг “Шүүхийн статистикийн мэдээлэл, тайлан гаргах журам”-ын дагуу шинэчлэгдсэн хураангуй маягтаар гаргаж, албан бичиг болон цахим хэлбэрээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнд jud_research@judcouncil.mn хаягаар тус тус хугацаанд нь хүргүүлэн ажиллажээ.

4.3. ШҮҮХИЙН ПРАКТИК СУДЛАЛ

Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанаар хянагдсан Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн дүн, өөрчлөгдсөн, хүчингүй болсон тогтоол, магадлалыг судалсан тухай тоймыг уламжлал ёсоор хийж гүйцэтгэлээ.

1. Эрүүгийн хэргийн талаарх шүүхийн практикийг судлах ажлын хүрээнд:

-2002 болон 2015 оны Эрүүгийн хуульд заасан “Хүн худалдаалах” гэмт хэргийг шийдвэрлэсэн байдлын судалгаа /2010-2019 он/;

-Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2.8 /Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хүнийг алах/, 11.7 дугаар зүйл /Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх/-ээр хянан шийдвэрлэсэн хэргийн судалгаа /2018-2019 он/;

-Төрийн тусгай албан хаагчдын үйлдсэн гэмт хэргийн судалгаа /2010-2019 он/;

-Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.2 дугаар зүйл /дээрэмдэх/-ээр шийдвэрлэсэн хэргийн судалгаа, энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд харгалзан үзэх нөхцөл байдлуудын талаарх судалгаа;

-Нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа хийлгэхээр прокурорт буцаасан хэргийн тойм /2018-2019 оны хагас жил/;

-Хяналтын шатны шүүхээс прокурорт буцаасан болон дахин хэлэлцүүлэхээр шүүхэд буцааж шийдвэрлэсэн хэргийн судалгаа /2020 оны эхний хагас жил/;

-Хяналтын шатны шүүхийн анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон давж заалдах шатны шүүхийн магадлалтай хэргийг шийдвэрлэсэн байдлын талаарх судалгаа /2017.07-2020.07/;

-Хяналтын шатны шүүхийн тогтоолд Ерөнхий шүүгчид гомдол гаргасан байдлын талаарх танилцуулга /2017-2019 он/.

2. Иргэний хэргийн талаарх шүүхийн практикийг судлах ажлын хүрээнд:

-Дундын өмчөөс үүсэх үүрэг, Бусдын үүргийг даалгаваргүйгээр гүйцэтгэх, Үндэслэлгүйгээр хөрөнгөжихтэй холбоотой хэргийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ;

-Компанийн тухай хуулиар хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн судалгаа /2011-2019 он/;

-Хяналтын шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн бага үнийн дүнтэй буюу 10 сая төгрөг хүртэлх үнийн дүнтэй нэхэмжлэлтэй иргэний хэргийн судалгаа /2017-2019 он/;

-Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн иргэний хэргийн судалгаа /2010-2019 он/;

-Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхүүдийн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан захирамжуудад хийсэн дүн шинжилгээ /2020 оны эхний хагас жилийн байдлаар/.

3. Захиргааны хэргийн талаарх шүүхийн практикийг судлах ажлын хүрээнд:

-Хяналтын шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн судалгаа /2016-2019 он/;

-Захиргааны хэргийн анхан, давж заалдах шатны шүүхүүдийн 2019 оны шийдвэрийн тогтвортой байдлын судалгаа;

- Хяналтын шатны шүүхийн Захиргааны хэргийн шүүх хуралдаанаар хүчингүй болгож хянан шийдвэрлэсэн хэргийн судалгаа /2018-2020.03/;

-Улсын дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоолуудад Газрын тухай хуулийн “бусдын эзэмшил газрыг солих буюу эргүүлэн авах, нөхөх олговор олгох”-той холбогдсон эрх зүйн зохицуулалтыг хэрхэн хэрэглэсэн талаарх хийсэн судалгаа /2015-2019 он/;

-Улсын дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэгдсэн шүүгчийн ёс зүйн хэргийн судалгаа /2017-2019 он/;

-Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн нэхэмжлэл хүлээн авч, хэрэг үүсгэх ажиллагаатай холбогдсон захирамжийн судалгаа /2020 он/.

Бусад судалгааны ажлын хүрээнд:

1. Монгол Улсын Шүүхийн тухай хууль, Шүүх байгуулах тухай хууль, Шүүгчийн орон тоо батлах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсэгт зориулан дараах судалгааг хийж гүйцэтгэв.

-Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн хэргийн судалгаа /2017-2019 он/;

- Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн орон тоо болон цаашид шаардагдах шүүгчдийн орон тооны судалгаа /2017-2019 он/;

-Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн ажлын ачааллын судалгаа /2017-2019 он/;

-Сум дундын шүүхийн хянан шийдвэрлэсэн хэргийн судалгаа /2017-2019 он/;

-Сум дундын шүүхийн шүүгчдийн орон тоо болон цаашид шаардагдах шүүгчдийн орон тооны судалгаа /2017-2019 он/;

-Сум дундын шүүхийн шүүгчдийн ажлын ачааллын судалгаа /2017-2019 он/.

2. Эрүүгийн хариуцлагыг ялгамжтай, тэгш, шударга ёсны зарчимд нийцүүлэн оногдуулах талаарх дараах судалгаа болон танилцуулгыг хийж гүйцэтгэв.

-Гадаадын зарим орны Эрүүгийн хариуцлагын зөвлөл болон эрүүгийн хариуцлага оногдуулах аргачлалын талаарх харьцуулсан судалгаа;

-Хяналтын шатны шүүхээр 2019 онд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.7 дугаар зүйл /Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах/-ээр шийдвэрлэсэн хэргийн судалгаа, энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд харгалзан үзэх нөхцөл байдлуудын талаарх танилцуулга;

-Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.2 дугаар зүйл /Дээрэмдэх/-ээр шийдвэрлэсэн хэргийн судалгаа, энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд харгалзан үзэх нөхцөл байдлуудын талаарх танилцуулга.

3.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2020 оны 1 дүгээр сард Нидерландын Вант Улсын Гаг хотноо байрлах Олон Улсын эрүүгийн шүүхэд хийсэн албан ёсны айлчлалд зориулж дараах судалгаа, танилцуулгыг хийж гүйцэтгэлээ.

-Шүүгчийн тусгай саналын талаарх судалгаа;

-Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх танилцуулга;

-Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан мөрдөн байцаалтын болон шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааны зохицуулалтын талаарх танилцуулга.

4.“Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх тогтолцооны үндэсний эрсдэлийн үнэлгээ”-ний шүүхийн байгууллагад холбогдох асуудлын талаарх багц судалгааг хийж гүйцэтгэсэн байна.

1) Шүүхээр хянан шийдвэрлэсэн авлига, албан тушаалын гэмт хэргийн судалгааг 2017-2019 оны байдлаар хийж гүйцэтгэв. Уг судалгааг:

- Анхан шатны шүүхээр Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан авлигын гэмт хэргийг зүйл тус бүрээр ангилан хянан шийдвэрлэсэн байдал,
- Анхан шатны шүүхээс авлигын хэргийг прокурорт буцаасан, хэрэгсэхгүй болгосон, цагаатгаж шийдвэрлэсэн байдал,
- Хяналтын шатны шүүхээр авлига, албан тушаалын гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн байдал,
- Авлига, албан тушаалын гэмт хэргийг шүүхээр хянан шийдвэрлэж байгаа хугацаа, өмгөөлөгчдийн оролцсон байдлаар гүйцэтгэлээ.

2) Шүүхээр хянан шийдвэрлэсэн эдийн засгийн гэмт хэргийн судалгааг 2017-2019 оны байдлаар хийж гүйцэтгэв. Уг судалгааг:

- Анхан шатны шүүхээс Эрүүгийн хуулийн 18 дугаар бүлэгт заасан Эдийн засгийн гэмт хэргийг зүйл тус бүрээр ангилан хянан шийдвэрлэсэн байдал,
- Анхан шатны шүүхээс эдийн засгийн гэмт хэргийг прокурорт буцаасан, хэрэгсэхгүй болгосон, цагаатгаж шийдвэрлэсэн байдал,
- Хяналтын шатны шүүхээр авлига, албан тушаалын гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн байдлын хүрээнд хийж гүйцэтгэлээ.

3) Шүүхээр хянан шийдвэрлэсэн мөнгө угаах гэмт хэргийн судалгааг 2018-2019 оны бүтэн жилийн байдлаар хийж гүйцэтгэсэн.

4) Эрүүгийн хуулийн 18, 22 дугаар бүлэгт заасан гэмт хэргүүдэд битүүмжилсэн эд хөрөнгийн талаарх судалгааг 2017-2019 оны байдлаар хийж гүйцэтгэсэн.

5) Шүүгчийн ёс зүйн асуудалд хариуцлага оногдуулсан байдлын судалгааг 2015-2019 оны бүтэн жилийн байдлаар хийж гүйцэтгэсэн.

5. Авлигатай тэмцэх газраас авлига, албан тушаалын 156 хэргийг шүүхэд шилжүүлснээс 68 хэргийг шүүх хянан шийдвэрлэсэн талаарх ташаа мэдээлэлд залруулга өгөх зорилгоор МҮОНРТ-ийн 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн “Гэмгүй гэмтнүүд” нэвтрүүлэгт дараах судалгааг бэлтгэн ярилцлага өгч оролцлоо. Үүнд:

-Авлига, албан тушаалын гэмт хэргийн ойлголт, шийдвэрлэж буй байдал, цаашид анхаарах асуудал;

-Хөөн хэлэлцэх хугацааны тухай ойлголт, дуусах үндэслэл, цаашид анхаарах асуудал;

-Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн дуулиант хэргийн судалгаа болно.

6. Санхүүгийн арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай орны жагсаалтаас Монгол Улсыг гаргах ажлын хэсэгт шүүгч Ч.Хосбаяр болон Шүүхийн практик судлалын хэлтэс амжилттай хамтран ажиллалаа. ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалт хийх багийнхантай шүүхийг төлөөлж уулзах бүрэлдэхүүнд Улсын Дээд шүүхийн шүүгч Ч.Хосбаяр, Шүүхийн практик судлалын хэлтсийн референт А.Баярцэцэг нар томилогдон ажилласан байна.

Хууль тогтоомжийн системчлэлийн ажлын чиглэлээр: 2020 онд Монгол Улсын хууль 92 хүлээн авч, үүнээс шинээр баталсан болон шинэчлэн найруулсан 14 хуулийг нэгдсэн санд оруулж, 74 хуульд нэмэлт, өөрчлөлт орж, 4 хууль хүчингүй болсныг эх хуульд тухай бүрт нь хийхийн зэрэгцээ нэгдсэн сан дахь хуулиудад өөрчлөлтийг орууллаа.

Улсын Их хурлын тогтоол 79;

Ерөнхийлөгчийн зарлиг 2;

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт 5, тогтоол 4;

Төрийн мэдээлэл сэтгүүлийн 48 дугаарыг хүлээн авч, эх хувь болон нэгдсэн санд оруулсан байна.

Улсын Их хурлын Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндсэн хуулийн цэцээс ирүүлж байгаа Монгол Улсын хууль, Улсын Их хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, тогтоол, “Төрийн мэдээлэл” сэтгүүлүүдийг дугаар бүрээр нь хүлээн авч шүүгч, ажилтнуудад эх хувиар болон дотоод сүлжээгээр дамжуулан ашиглуулж, лавлагаа өгч, Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн танхим болон Шүүхийн практик судлалын хэлтсээс гаргасан тойм, зөвлөмжүүдийг тухай бүрт нь цахим санд оруулан шүүхийн мэдээллийн санг баяжуулан ажиллаж байна.

Ном товхимол, сэтгүүл эрхлэн гаргах чиглэлээр: “Монголын төр, эрх зүй” сэтгүүлийн 2019 оны 4, 2020 оны 1, 2, 4 дүгээр улирлын дугаарыг эрхлэн хэвлүүлээ. Мөн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар номын хэвлэлийн эх бэлтгэлийн ажлыг гүйцэтгэж байна.

4.4 ШҮҮХИЙН ТӨСӨВ, САНХҮҮ, ХАНГАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2020 оны төсвийн багцыг 21.2 тэрбум төгрөгөөр төлөвлөн Сангийн яам, Шүүхийн Ерөнхий зөвлөлд хүргүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулиар Улсын дээд шүүхийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багц 9.2 тэрбум төгрөгөөр батлагдсанаас урсгал үйл ажиллагааны санхүүжилт 4.7 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын санхүүжилт 4.5 тэрбум төгрөг байв.

Батлагдсан төсвийн хүрээнд хэлтсийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахаас гадна хяналтын шатны шүүх үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгаа болон шүүхийн үйлчилгээг хүргэх ая тухтай нөхцөлийг бүрдүүлэх, шүүгч эдийн засгийн хувьд бусдаас хараат бус ажиллах, амьдрах баталгааг хангах, шүүхийн тухай багц хуулиудыг хэрэгжүүлэхэд анхаарч, төсвийн хуваарилалтыг хийж, хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

Түүнчлэн 2020 онд дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын нөхцөл байдал үүссэнээс шалтгаалан улс орны нийгэм, эдийн засгийн хүндрэлтэй цаг хугацаанд батлагдсан төсвийг бодит хэрэгцээ шаардлагад нийцүүлэн төсвийн сахилга баттай, үр ашигтай оновчтой хуваарилах зарчмыг баримталснаар улсын төвлөрсөн төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилтээр 4.7 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын санхүүжилтээр 0.0 тэрбум төгрөгийн тус тус санхүүжилт авч урсгал төсвийн зардалд 3.5 тэрбум төгрөгийн зарлага гаргаж, төсвийн гүйцэтгэл 74.1 хувьтай гарч байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар Улсын Дээд шүүхийн урсгал үйл ажиллагааны зардлыг 5.2 тэрбум төгрөгөөр баталсан болно.


Улсын дээд шүүхийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны жилийн эцсийн болон 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гарган тайлагнаж, аудит хийлгэх, нэгтгүүлэхээр Үндэсний Аудитын газар, Сангийн яамны Төрийн сангийн газруудад тус тус хүргүүлсэн байна.

Шүүхийн санхүүгийн үйл ажиллагаанд 2020 онд хийгдсэн ажлуудаас тоймлон авч үзвэл:

Шүүхийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, их засварын ажлын судалгаанд үндэслэн 2020 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг батлуулсан бөгөөд уг төлөвлөгөөний хүрээнд худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангасан байна. Тайлант онд “Шүүгчийн амь нас, эрүүл мэндийн

даатгал”, “Тээврийн хэрэгслийн даатгал”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу нээлттэй цахим хэлбэрээр зарлаж “Ард даатгал” ХК-тай гэрээ байгуулан ажиллалаа.

Улсын дээд шүүхийн 2020 оны урсгал үйл ажиллагааны санхүүжилтийг гүйцэтгэл, зарцуулалт гаргасан бүлгийн дүнгээр харуулбал:



Шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны нийтлэг журмын 7.1.3-т “шүүгч, ажилтныг шаардлагатай тавилга, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах” гэж заасны дагуу батлагдсан төсвийн хүрээнд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас хөрөнгө худалдан авах тухай зохих зөвшөөрлийг авч, шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах дээрх ажлуудыг хэрэгжүүлэхээр эрэмбэлсний дагуу 96.0 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж шинээр худалдан авсан байна.

Улсын дээд шүүхийн үндсэн хөрөнгийн бүртгэлд байсан 245.8 сая төгрөгийн балансын үнэ бүхий автомашин, тавилга, тоног төхөөрөмжийг “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн тэмдэглэлийг үндэслэн актлах, балансаас балансад шилжүүлэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлснээр зохих шийдвэрийг гаргуулав.

Иймээс дээрх шийдвэрийг үндэслэн Замын-Үүд дэх сум дундын шүүх, Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх болон Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхүүдэд автомашинуудыг, бусад тавилга тоног төхөөрөмжийг хүсэлт ирүүлсэн 13 шүүхүүдэд саналд тулгуурлан хуваарилан хүргүүлж, холбогдох бусад ажиллагааны зохион байгуулалтыг хийж ажилласан.

Шүүхийн хангамж, үйлчилгээний ажлын хүрээнд: Улсын дээд шүүхийн санхүүгийн анхан шатны баримт хөтлөлт, нягтлан бодох бүртгэлийг УСНББОУСтандартад нийцүүлэн 2019 оны жилийн эцсийн болон 2020 оны хагас

жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн зарлагын мэдээ, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, татварын тайлан мэдээг хуульд заасан цаг хугацаанд нь гаргаж, тооцоо нийлж ажиллалаа.

Цар тахлын үед хяналтын шатны шүүн таслах ажиллагааны аюулгүй байдлыг хангаж, болзошгүй эрсдэлийг бууруулах зорилгоор онлайн хэлбэрээр шүүх хуралдааныг зохион байгуулахад шаардагдах тоног төхөөрөмж, сүлжээний төхөөрөмж зэргийг худалдан авахад 14.1 сая төгрөг зарцуулжээ.

Мөн шүүгч, ажилтнуудыг шаардлагатай бичиг хэрэг, хангамжийн материалаар хангах болон бараа материал, ном сонин захиалах, хэвлэх зардалд 112.5 сая төгрөг, байр ашиглалтын зардалд 85.9 сая төгрөг, урсгал засвар, багаж тоног төхөөрөмж, урсгал засварын зардалд 165.7 сая төгрөг, цалин болон НДШ-д 2 940.6 сая төгрөг, мэдээллийн технологийн үйлчилгээ, газрын төлбөр зэрэг бусад зардалд 200.5 сая төгрөгийн тус тус зарлага гаргаж, 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг батлагдсан төсвийн дагуу сар бүр бүрэн санхүүжүүлж, дэмжин ажилласан байна.

Ажиллагсадын нийгмийн асуудлыг дэмжихэд зориулж давхардсан тоогоор 75 хүнд 9.7 сая төгрөгийн буцалтгүй тусламж, тэтгэвэрт гарахад олгодог нэг удаагийн буцалтгүй тусламжийн 17.2 сая төгрөгийн дэмжлэгийг холбогдох тушаал шийдвэрийн дагуу олгосон байна.

Шүүгч ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулах, ая тухтай байдлыг хангах, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, ковид19 цар тахлын үед хүний хөл урсгалыг саармагжуулах, дотоод нөөц бололцоондоо тулгуурлах зорилгоор эмчийн өрөөг 9.4 сая, ажиллагсадын хоолны өрөөг 11.7 сая төгрөгөөр тус тус тохижууллаа.



Зураг дээр: Ажилчдын цайны өрөө



Зураг дээр: Эмчийн өрөө

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын www.shilendans.gov.mn болон Улсын дээд шүүхийн вэб сайт дахь Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны батлагдсан төсөв, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, бүтэн жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш хэмжээтэй зардал зэрэг холбогдох шаардлагатай мэдээ, мэдээллүүдийг цаг тухай бүрт нь хуулийн хугацаанд оруулах, шүүхийн 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг tender.gov.mn сайтад байршуулах зэргээс гадна холбогдох тайлан, мэдээг гаргаж Сангийн яам болон бусад газруудад хуулийн хугацаанд хүргүүлэн ажиллалаа.

“Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн мэдээллийн систем”-ийн програм хангамжид Улсын дээд шүүхийн 2020 оны жилийн эцсийн хөрөнгийн үлдэгдэл, холбогдох мэдээллийг цаг хугацаанд нь багтаан оруулж, биелэлтийг хангаж, гүйцэтгэсэн байна.

Дүгнэвэл:

Шүүхийн 2020 оны урсгал төсөв өмнөх оны урсгал төсвөөс 20.8 хувиар буюу 1.2 тэрбум төгрөгөөр буурч, хөрөнгө оруулалтын төсөв 12 хувь буюу 0.48 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагдсан боловч улс орны нийгэм, эдийн засгийн байдлаас шалтгаалан хөрөнгө оруулалтын зардлыг буцаан төвлөрүүлсэн байна. Батлагдсан төсөв хуваарилсан санхүүжилтийг зориулалтын дагуу холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хяналтын шатны шүүхийн хэвийн ажиллагааг хангахад зарцуулж, ажиллах нөхцөл дээшлүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх ажлуудад дэмжлэг үзүүлэн ажиллалаа.

2020 онд Үндэсний Аудитын газраас хийгдсэн санхүүгийн тайлангийн аудитад “Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль,

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргаж бидний ажлыг дүгнэсэн билээ.

Түүнчлэн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Үндэсний Аудитын газраас “2019 оны шилэн дансны хэрэгжилт”-ийн аудитыг тусад нь хийсэн бөгөөд өгөгдсөн зөвлөмжийн дагуу мэдээллийг нэмж оруулан хамтарч ажиллалаа.

Мөн 2019 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд Сангийн яамнаас үнэлэлт хийж, “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2019 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд үнэлгээ хийсэн тухай тайлан”-г УИХ-аар хэлэлцүүлж, 85%-тай буюу “Сайн” үнэлгээгээр үнэлэгдсэн байна.

Хяналтын шатны шүүхийн хэвийн үйл ажиллагааг хангахад эдийн засгийн баталгааг бэхжүүлэх, дэд бүтцийг сайжруулах, бодит хэрэгцээ шаардлагад нийцсэн шаардлагатай хангамж, үйлчилгээний хэрэгцээг судалж, цаашид 2021-2022 оны төсвийн жилүүдэд батлагдсан төсвийн хүрээнд эрэмбэлэн төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлага мөн үүсч байна.

4.5 ШҮҮХИЙН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДАЛ

Улсын дээд шүүхийн Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс нь 2020 онд шүүхийн нээлттэй, ил тод байдлыг хангах, шүүхийн үйл ажиллагааг сурталчлах зэрэг ажлыг зохих түвшинд хэрэгжүүлэн ажиллалаа.

Мэдээ, мэдээллийн ажлын хүрээнд: Улсын дээд шүүхийн Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс нь 2020 онд Улсын дээд шүүхийн шүүн таслах болон бусад үйл ажиллагааны талаар давхардсан тоогоор өдөр тутмын сонинд 67, телевизэд 180, радиод 61, вэб сайтуудад 521 мэдээ, мэдээлэл бэлтгэн нийтлүүлж нэвтрүүлжээ.

Телевизийн нэвтрүүлгийн ажлын хүрээнд: Улсын дээд шүүхийн Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсээс МҮОНТ-тэй хамтран бэлтгэдэг “Монгол Улсын нэрийн өмнөөс” нэвтрүүлгийн 13 дугаарыг олон нийтэд хүргэсэн байна. Үүнд:

1.Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс хүүхдийн эсрэг гэмт хэрэг, ялын бодлого, хүүхэд гэмт хэргийн хохирогч болж буй шалтгаан нөхцөл, сэрэмжлэх зүйлийн талаар, шүүхийн сэтгэл зүйчийн ярилцлага болон хүүхэдтэй холбоотой бусад асуудлын талаарх ярилцлага, сурвалжилга /2020.01.28/

2.Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс бэлтгэсэн захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүхийн үйлчилгээний талаарх ярилцлага, сурвалжилга /2020.02.17/

3.Төв аймаг дахь анхан болон давж заалдах шатны шүүхүүдээс бэлтгэсэн тухайн шүүхүүдийн онцлог, ачаалал, зам тээврийн осолтой холбоотой гэмт хэрэг, ялын бодлогын талаарх ярилцлага, сурвалжилга /2020.03.03/

4.Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс хянан магадлангийн хурал, шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоон үзүүлэлт, ажлын ачааллын талаарх ярилцлага, сурвалжилга /2020.03.10/

5.Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс алслагдсан дүүргийн шүүхийн онцлог, шүүхийн тамгын газрын үйл ажиллагаа, эвлэрүүлэн зуучлал, архидан согтуурснаас үүдэлтэй гэмт хэргийн талаар иргэдэд сэрэмжлүүлэх талаарх ярилцлага, сурвалжилга /2020.07.07/ -2020.07.28-нд давтсан.

6.Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээс хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг, нэг хэрэг дээр хийгддэг ажиллагаа, хэргийг эцэслэн шийдвэрлэх, буцаах ойлголтын ялгаа, ялын бодлогын талаарх ярилцлага, сурвалжилга /2020.08.10/

7.Баянгол, Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхүүдээс шүүхийн үйлчилгээ, хэргийн ачаалал, нэхэмжлэл хүлээн авах, нэхэмжлэлийг хариуцагчид гардуулах, шүүхийн мэдэгдэх хуудасны талаарх ярилцлага, сурвалжилга /2020.08.24/

8.Төв аймаг дахь Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс тус аймгийн нутаг дэвсгэрт байрладаг ШШГЕГ-ын харъяа 415-р хаалттай хорих анги, 417-р нээлттэй хорих анги, Төв аймаг дахь ШШГГ-т хоригдож байгаа хоригдлын хугацаанаас өмнө тэнсэн суллаж хяналт тогтоох тухай, хорих байгууллагад ял эдлүүлэх дэглэм солих тухай мөн хөдөө орон нутгийн шүүхийн онцлог, ажлын ачааллын талаарх ярилцлага, сурвалжилга /2020.09.01/

9.Увс аймгийн анхан болон давж заалдах шатны шүүхээс орон нутгийн шүүхийн онцлог, хэргийн ачаалал, тамгын газрын үйл ажиллагааны талаарх ярилцлага, сурвалжилга /2020.09.15/

10.Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхээс шүүхийн харьяаллын онцлог, хэргийн ачаалал, согтууруулах, мансууруулах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай ярилцлага, сурвалжилга /2020.09.29/

11.Цахим шүүх хуралдааны (Live.shuukh.mn) талаарх ярилцлага, сурвалжилга /2020.10.20/

12.Шүүхийн байрны асуудал, хүндрэл бэрхшээлийн талаарх сурвалжилга, ярилцлага /2020.11.03/

13.Ховд аймгийн анхан болон давж заалдах шатны шүүхээс хөдөө орон нутгийн шүүхийн онцлог, шүүхээр шийдвэрлэгдэж буй хэргийн тоон үзүүлэлт, зонхилох гэмт хэрэг, шалтгаан нөхцөл, ажлын ачааллын талаарх ярилцлага, сурвалжилга /2020.11.17/

Сонин, сайтын нийтлэлийн ажлын хүрээнд: Шүүхийн талаар бодит ойлголт олон нийтэд хүргэх үүднээс шүүх, шүүгчийн үйл ажиллагаа, шүүхийн шийдвэртэй холбоотой давхардсан тоогоор ярилцлага, нийтлэл, бүтэн жил, улирлын шүүн таслах ажлын дэлгэрэнгүй мэдээлэл, эмгэнэл, хяналтын шатны шүүхийн журам давхардсан тоогоор нийт 68-ыг сонин, сайтад нийтлүүлжээ.

Сонин, сайтын тоймын ажлын хүрээнд: Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчид, Тамгын газрын дарга болон холбогдох бусад албан тушаалтныг мэдээллээр хангах зорилгоор шүүх, шүүгчтэй холбоотой болон бусад цаг үеийн үйл явдалтай холбоотой мэдээллийн сонин, сайтын тоймыг 228 өдөр бэлтгэн дотоод сүлжээгээр дамжуулан тараажээ.

Шүүхээс хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах сургалтын ажлын хүрээнд: Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан “Шүүхийн захиргааны ажилтан бэлтгэх” сургалтад ХМОНХХ-ийн дарга Р.Ганпүрэв “Шүүхээс хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах харилцаа” сэдвээр 2020 оны 9 дүгээр сард хичээл заасан.

Бусад ажлын хүрээнд: “Улсын дээд шүүхэд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” гарын авлага 500ш, “Улсын дээд шүүхэд захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдвээр гарын авлага 500ш тус тус хэвлүүлж 2020 оны 01 дүгээр сард Мэдээлэл лавлагаанд байршуулан нийт 400 гаруйг иргэдийн хүртээл болгожээ. Мөн Улсын дээд шүүхийн хяналтын шатны хуралдаанд алсын зай /zoom/-наас оролцсон 70 орчим хүнтэй утсаар нэг бүрчлэн ярилцаж, санал асуулга авч, Тамгын газар болон холбогдох танхимд танилцуулан ажиллав.

4.6 ЕРӨНХИЙ ШҮҮГЧИЙН АЖЛЫН АЛБА

2020 оны бүтэн жилийн байдлаар 55 албан бичиг, 110 өргөдөл хүлээн авч, шийдвэрлэсэн үүнээс өргөдөл 1, албан бичиг 1 үлдэгдэлтэй байна.

Иргэдийг сар бүрийн 4 дүгээр долоо хоногийн Пүрэв гаригт, орон нутгаас ирсэн иргэдийг өдөр харгалзахгүй хүлээн авч, Ерөнхий шүүгчтэй уулзахаар урьдчилан бүртгүүлж, хүсэлт гаргасан 115 иргэнтэй уулзан санал хүсэлтийг нь сонсож, мөн тэдний санал, хүсэлтийг Ерөнхий шүүгчид тухай бүрт нь танилцуулж, зохих хариуг өгч ажиллав.

Ерөнхий шүүгчийн ажлын албанд нийт 381 хэрэг хүлээн авч, Ерөнхий шүүгчид танилцуулан холбогдох хуульд заасан журмаар хариу өгсөн байна. Үүнд:

1. Иргэний 97 хэрэг хүлээн авч, 86 хэргийн хариуг өгч, одоогоор 11 хэргийн үлдэгдэлтэй.
2. Захиргааны 135 хэрэг хүлээн авч, 130 хэргийн хариуг өгч, одоогоор 5 хэргийн үлдэгдэлтэй.
3. Эрүүгийн 149 хэрэг хүлээн авч, 136 хэргийн хариуг өгч, одоогоор 13 хэргийн үлдэгдэлтэй байна.

Улсын дээд шүүхийн дотоод аудитор нь байгууллагын оршин байгаа алдаа зөрчлийг тайлагнахаас илүүтэйгээр байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, түүний үнэ цэнийг нэмэгдүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, гарч болох алдаанаас сэргийлэх, дотоод хяналтын сул талыг сайжруулахад чиглэн ажиллав.

Дотоод аудит нь Монгол Улсын Төсвийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 тоот тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм” болон Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт (ДАМПОУС)-ийн хүрээнд шүүхийн захиргааны байгууллагыг бэхжүүлэх, шүүхийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд удирдлагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, дотоод хяналтын үр ашигтай байдлыг хангах зэрэг үүргүүдийг гүйцэтгэдэг.

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч (төсвийн ерөнхийлөн захирагч)-ийн захирамжаар Дотоод аудиторын жилийн ажлын төлөвлөгөөг батлуулан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлж ажиллав. Тухайлбал:

Нэг. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар:

- Эрсдэлд суурилсан 2020 оны дотоод аудитын жилийн төлөвлөгөөг боловсруулан Ерөнхий шүүгчийн 2020 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 33 дугаар захирамжаар батлуулан, мөн албаны даргаар улирлын төлөвлөгөөг давхар батлуулан төлөвлөгөөний дагуу удирдамж гарган ажилласан.
- “Шүүхийн захиргааны хяналт-шинжилгээний сар тутмын мэдээ”-ний хэрэгжилтэд аудит хийж тайлан бэлтгэсэн;
- Хэргийн хөдөлгөөний урсгал, бичиг хэргийн эргэлтийн харилцаанд үйлчилж буй хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтэд аудит хийж тайлан бэлтгэсэн;
- “Шүүхийн хүний нөөцийн програм ашиглах журам”-ын хэрэгжилт, гүйцэтгэлийн үр дүнд нийцлийн аудит хийж, тайлан зөвлөмж бэлтгэсэн.

- Улсын дээд шүүхийн архивын баримтын эргэлт, хадгалалтын үйл ажиллагаанд хэрэгжиж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэд аудит хийж, тайлан бэлтгэсэн;
- Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрийн хэрэгжилтэд аудит хийж тайлан, зөвлөмж гаргасан.

Хоёр. Төсөв, санхүүгийн хяналт, шалгалтын талаар:

- Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих ажлыг зохион байгуулах, тайланг Сангийн яаманд цаг тухай бүр хүргүүлсэн;
- Шилэн дансны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус хуулийн 8 дугаар зүйлийн 2-т заасны дагуу дотоод хяналтыг зохион байгуулж 2020 оны батлагдсан төсөв, 1 дүгээр улирлын төсвийн гүйцэтгэл, 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ зэргийг шилэн дансанд байршуулж жигдрүүлснээр <http://shilendans.gov.mn/> сайтад мэдээлэл хуулийн хугацаанд тогтмол тавигдаж хэвшсэн;
- Үндэсний аудитын газраас байгууллагын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх бэлтгэл ажлыг хангуулж, 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр Үндэсний аудитын газраас ирж ажилласан аудитор Ц.Цэрэнхүүд дотоод аудитаас хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг танилцуулсан;
- Цалингийн тооцоолол, бодолт, олголтод хууль тогтоомжийн нийцлийн аудитыг удирдамж, төлөвлөгөөний дагуу 2018 он, 2019 он, 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар хамруулан үзэж аудит хийн, тайлан дүгнэлт бэлтгэсэн;

Гурав. Бусад ажлын талаар:

- Хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд нь гарган цахимаар мэдүүлсэн;
- Архивт 2019 оны дотоод аудитын материалыг 2020 оны 1 сард хугацаанд нь шилжүүлсэн;
- Дотоод аудиттай холбогдолтой ажлын хэрэгцээнд шаардлагатай гарын авлага материал, мэдээллийн сан бүрдүүлэн ажилласан.
- Удирдлагын академийн зохион байгуулж буй “Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт”-д хамрагдан сертификат авсан;

4.7 ШҮҮХИЙН ГАДААД ХАРИЛЦАА ХАМТЫН АЖИЛЛАГАА

Шүүхийн гадаад харилцаа жилээс жилд өргөжин тэлж шүүгч, ажилтнууд тив дэлхийн болон олон улсын бүсийн чуулга уулзалт, эрдэм шинжилгээний бага хуралд оролцож шүүн таслах ажиллагааны талаарх туршлага судлах ажил өргөжсөөр байна. Энэ жил цар тахлын улмаас төлөвлөгдөөд байсан гадаад улсад хийгдэх айлчлал болоод сургалтууд тодорхойгүй хугацаагаар хойшлоод байна.

Тухайлбал 2020 оны 5 дугаар сард Казахстан улсад зохион байгуулагдах байсан ШХАБ-ын гишүүн орнуудын Дээд шүүхийн тэргүүн нарын уулзалт, ОХУ-ын Санкт Петербург хотноо зохион байгуулагдах байсан Олон Улсын эрх зүйн форум, БНСУ-ын Шүүхийн үндэсний захиргаанаас Монголын шүүхийн шүүгч, ажилтан нарт зориулсан сургалт арга хэмжээг тус тус дурдаж болох юм.

- Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Х.Батсүрэн, шүүгч Д.Эрдэнэбалсүрэн, Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ч.Отгонбаяр, Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч И.Ганбат, Тамгын газрын дарга Ж.Наранпүрэв, Гадаад харилцаа хамтын ажиллагааны албаны дарга Д.Тулга нар Олон Улсын Эрүүгийн шүүхийн Ерөнхийлөгч Чиле Ебоу-Осүжийн урилгаар Нидерландын Вант Улсын Гаага хотноо 2020 оны 1 дүгээр сарын



21-26-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Эрүүгийн процессын ажиллагаа, шийдвэр гаргах хугацааны хязгаар, түүний хэрэглээ-Туршлага, үзэл баримтлал” сэдэвт уулзалтад;

-шүүгч Б.Батцэрэн, Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч О.Жанчивнямбуу, Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Н.Одонтуул нар НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газраас 2020 оны 02 дугаар сарын 23-26-ны өдрүүдэд Катар Улсын Доха хотноо зохион байгуулагдах “Дэлхийн шүүхийн хамтын ажиллагааны /интеграц/ сүлжээ” сэдэвт дээд хэмжээний хуралд;

-Улсын дээд шүүхийн Гадаад харилцаа хамтын ажиллагааны албаны дарга Д.Тулга 2020 оны 10 дугаар сарын 06-ны өдөр Монгол Улс болоод БНХАУ-ын Хууль

зүйн яам хоорондын эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний хэрэгжилтийн талаар зөвлөлдөх цахим уулзалтад;

- Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.Ганзориг, Гадаад харилцаа хамтын ажиллагааны албаны дарга Д.Тулга нар Бүгд Найрамдах Казахстан улсын Нурсултан хотноо 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулагдсан Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнуудын Дээд шүүхийн тэргүүн нарын 15 дахь удаагийн уулзалтад ажиглагч орны хувиар;




Ерөнхий шүүгч Д.Ганзориг

-Ерөнхий шүүгчийн ажлын албаны зөвлөх Д.Тунгалаг, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны дарга Д.Тулга нар БНЭУ-ын Лакноу хотноо 2020 оны 11 дүгээр сарын 5-11-ны өдрүүдэд цахимаар зохион байгуулагдсан “Дэлхийн Ерөнхий шүүгч нарын дээд хэмжээний уулзалт”-д;

-шүүгч Д.Эрдэнэбалсүрэн, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны дарга Д.Тулга нар Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага /ЕАБХАБ/-ын Ардчилсан институт, хүний эрхийн алба, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газартай хамтран 2020 оны 11 дүгээр сарын 25-26-ны өдрүүдэд “Төв Ази дахь эрүүгийн шударга ёс: Өнөөгийн хөгжил, тулгарч буй саад бэрхшээл, COVID-19 халдварын нөлөө” сэдэвт цахим уулзалтад;

-шүүгч Ч.Хосбаяр Олон Улсын Эрүүгийн Шүүхийн шүүгчид нэр дэвшсэнтэй холбогдуулан холбогдох зохион байгуулалтын арга хэмжээ, нэр дэвшигчийн видео болон цахим танилцуулгыг бэлдэж хийлгүүлэн хүргүүлэх, цахим хуралдаанд 3 удаа оролцуулах ажлыг тус тус зохион байгуулан ажиллалаа.



Гадаад хамтын ажиллагааны хүрээнд:

-Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн М.Батсуурь 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдөр Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага /ЕАБХАБ/-ын Ардчилсан институт, хүний эрхийн албаны Сонгуулийн асуудал эрхэлсэн газрын дэд захирал Улви Ахундлу, Монгол Улсыг хариуцсан зөвлөх Кеара Касталдо нарыг;



-Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Х.Батсүрэн, Тамгын газрын дарга Ж.Наранпүрэв нар 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Олон Улсын хөгжлийн эрх зүйн байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгч Тара Нил тэргүүтэй төлөөлөгч нарыг;



-Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Х.Батсүрэн, Тамгын газрын дарга Ж.Наранпүрэв нар 2020 оны 05 дугаар сарын 06-ны өдөр Бүгд Найрамдах Хятад Ард улс (БНХАУ)-аас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Чай Вэньруй тэргүүтэй төлөөлөгч нарыг;



-Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.Ганзориг, Тамгын газрын дарга Ж.Наранпүрэв нар ОХУ-аас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Азизов Искандер Кубарович тэргүүтэй төлөөлөгч нарыг 2020 оны 06 дугаар сарын 18-ны өдөр тус тус хүлээн авч уулзлаа.



Эрх зүйн туслалцаа /шүүхийн даалгавар/-ны хүрээнд: Шүүхийн даалгавар буюу эрх зүйн туслалцааг хилийн чандад илгээх болон хилийн чанадаас ирсэн хүсэлтийг Иргэний хэргийн хувьд хариуцах Дээд шатны байгууллага нь Улсын Дээд шүүх бөгөөд гадаад улсад нийт 3 шүүхийн даалгавар илгээснээс БНСУ-д 1, Япон

Улсад-2 шүүхийн даалгавар илгээсэн ба өнгөрсөн онд Болгар Улсад илгээсэн 1 шүүхийн даалгаврын хариу ирүүлснийг холбогдох шүүхэд нь дамжуулсан байна.

Харин БНСУ-аас 1, Чех улсаас-1 шүүхийн даалгавар тус тус ирснийг харьяалах шүүхэд хүргүүлэн гүйцэтгүүлэх арга хэмжээг авсан байна.

Шүүгч, ажилтан нарт зориулан дэлхий дахинд болж буй шүүх болон хуулийн цаг үеийн мэдээ, мэдээллийг орчуулан хүргэх ажлыг тогтмол хийж ажиллав. Тухайлбал, 7 удаа 32 гадаад орны шүүх болон хуулийн талаар мэдээ бэлтгэн шүүгч ажилтан нарт хүргэсэн байна.

Гадаад улс орны шүүхийн үйл ажиллагааны туршлага судалж, манай улс оронд нэвтрүүлж болох зүйлийг хэрэгжүүлэх талаар анхаарал хандуулан ажиллаж байна.

-----oO-----